



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2001 оны 12 дугаар  
сарын 09 ны өдөр

Дугаар 59


Улаанбаатар  
хот

Гадаадад суралцуулах тухай

“Сонгон шалгаруулалт явуулах тухай” Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2001 оны 13 дугаар тушаал, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлтийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дорж овогтой Долгорсүрэнг эдийн засгийн чиглэлээр АНУ-ын Хавайн Их сургуулийн магистрантурт, Жамьянсүрэн овогтой Чимэгбатыг мэдээллийн технологийн чиглэлээр АНУ-ын Вэстерний Олон Улсын Их сургуулийн магистрантурт, Шагдарсүрэн овогтой Бүжинг бизнесийн удирдлагын чиглэлээр Австрали улсын Мельбурн хотын Свинберний Технологийн Их сургуулийн магистрантурт, Пүрэвжав овогтой Болормааг төрийн захиргааны удирдлагын чиглэлээр Австрали улсын Гриффитийн Их сургуулийн магистрантурт тус тус 2 жилийн хугацаагаар, Дорж овогтой Дэмчигсүрэнг урлагийн менежментийн чиглэлээр Англи улсын Рехэмптоны Их сургуулийн магистрантурт, Намжилсүрэн овогтой Оюунтунгалагийг сэтгүүл зүйн чиглэлээр Швейцари улсын Монтро хотын Олон Улсын Хэвлэл Мэдээллийн академийн магистрантурт тус тус 1 жилийн хугацаагаар 2001-2002 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /Л.Баттулга/-т тус тус даалгасугай.



САЙД - 2

*С. Эрвэн*

А.ЦАНЖИД

*А.Ш.Б.А. /.../*